



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 36

Мандалговь

Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах,  
хөрөнгөд үнэлгээ тогтоож, худалдах  
зөвшөөрөл олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1, 77.3 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2022 оны 06 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 09 дүгээр тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит арванхоёрдугаар хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 20,000,000 /хорин сая/ төгрөгийн балансын үнэтэй, 16,000,000 /арван зургаан сая/ төгрөгийн үлдэгдэл өртөг бүхий DFAC маркийн Бохирын автомашиныг нэгдүгээр хавсралтын дагуу актлах, 500,000 /таван зуун мянган/ төгрөгийн балансын үнэтэй үлдэгдэл өртөггүй FT200 маркийн бага оврын тракторыг хоёрдугаар хавсралтын дагуу худалдах доод үнийг 200,000 төгрөгөөр тогтоон нээлттэй дуудлагын худалдаагаар худалдахыг зөвшөөрсүгэй.

2. Орон нутгийн өмчийн газар (Б.Адъяасүрэн), Гурвансайхан сумын Засаг даргын тамгын газрын дарга (Б.Энхтуяа) нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай.

2.1 Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг орон нутгийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэх;

2.2 Актлах хөрөнгийг сум, байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор акталж, акталснаас гарсан сэлбэг, материалыг эргэлтийн хөрөнгөд бүртгэх, хаягдал төмрийг “Дарханы төмөрлөгийн үйлдвэр” ТӨХК-д тушаах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.3 Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4 Энэ тогтоолын биелэлтийг 2022 оны 4 дүгээр улиралд багтаан Орон нутгийн өмчийн газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга (Ц.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ОД-ЭРДЭНЭ



Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн  
86 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт

Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын актлах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалт ад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
			Се-ри-ар	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Тусгай зориулалтын	DFAC	-	-	2012	2013.01.13	12023382	СУ4102-С3F	3200	99000	20,000,000	3,999,999.96	16,000,000.04
Хөрөнгийн дүн													16,000,000.04 /арван зургаан сая дөрвөн мөнгө/ төгрөг

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2022 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн  
86 дугаар тогтоолын хоёрдугаар хавсралт



Гурвансайхан сумын Засаг даргын Тамгын газрын худалдах тээврийн хэрэгслийн мэдээлэл

№	Тээврийн хэрэгслийн төрөл	Марк	Улсын бүртгэлийн		Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон огноо	Тээврийн хэрэгслийн			Нийт гүйлт /км/	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Худалдах доод үнэ
			Сери	Дугаар			Арлын дугаар	Моторын дугаар	Моторын эзлэхүүн /см3/				
1	Трактор /мехенизм/	FT200	-	-	2007	2018.12.28	A80277	16.12	2200	8000	500.000	500.000	200,000
Хөрөнгийн дүн													
											500,000		200,000 /хоёр зуун мянга/ тегрэг